



## БУЛГАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

### САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сэлэнгэ сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

**Аудитын код:** БУА-2023/82/НА-СА-ТШЗ

Цахим хуудас: [www.audit.mn](http://www.audit.mn)  
Булган аймаг  
2022 он

Дарга, тэргүүлэх аудитор: Б.Эрдэнэ

Утас: **7034-2580**

Цахим хаяг: [erdeneb@audit.gov.mn](mailto:erdeneb@audit.gov.mn)

Аудитын менежер: Ж.Энхцоодол

Утас: **7034-2716**

Цахим хаяг: : [enkhtsoodolj@audit.gov.mn](mailto:enkhtsoodolj@audit.gov.mn)

ЦЭСБ аудит ХХК-ийн захирал: Ч.Цэрэннадмид

Утас: **9511-2689**

Цахим хаяг: [tsesb.audit@gmail.com](mailto:tsesb.audit@gmail.com)

**Аудитор Ш.Ганчимэг**

Утас: **99377360**

Цахим хаяг: [shagdarganchimeg44@jmail.com](mailto:shagdarganchimeg44@jmail.com)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## АГУУЛГА

---

1. Хараат бус аудиторын дүгнэлт.....	3-4
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл .....	5-12
3. Санхүүгийн тайлангийн тодруулга.....	13
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа.....	13
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин.....	13
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	13-14
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт.....	14-16
4. Аудитын тайлан.....	17
4.1 Ерөнхий зүйл .....	17
4.2 Материаллаг байдал .....	17
4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт.....	17
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	17-18
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	19
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал .....	19
5. Аудитын илрүүлэлт .....	19-20
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл .....	21

### Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
НББ	Нягтлан бодох бүртгэл
БШУС	Боловсрол, шинжлэх ухааны сайд

# 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



## БУЛГАН АЙМГИЙН ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Анхдагчдын өргөн чөлөө 1-120,  
Жаргалант баг, Булган сум, Булган аймаг, 63082  
Утас/Факс: 7034-2580  
E-mail: bulgan@audit.gov.mn

2023.02.24 № 204  
танай \_\_\_\_\_ ны № \_\_\_\_\_ т

СЭЛЭНГЭ СУМЫН ЕРӨНХИЙ  
БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН  
ЗАХИРЛЫГ ҮҮРГИЙГ ТҮР ХАВСРАН  
ГҮЙЦЭТГЭГЧ Т.ДОРЖДЭРЭМ ТАНАА

### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сэлэнгэ сумын ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Тус сургуулийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

#### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

#### Асуудлыг онцолсон хэсэг

Сэлэнгэ сумын ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны үйл ажиллагааны зардлыг улсын төсвөөс 1,092,754.1 мянга, орон нутгийн тусвөөс төсвөөс 404,757.5 мянган төгрөгөөр санхүүжүүлэхээр баталснаас нийт зардлын гүйцэтгэл 100 хувьтай хэрэгжжээ.

Тайлант онд БШУС-ын 2022 оны 11 дүгээр сарын 08-ны өдрийн А/452 дугаар тушаалаар нөхөн хөнгөлөлтийн зардалд хуваарилсан 29,970.0 мянган төгрөгөөс 28,077.8 мянган төгрөгөөр төрийн худалдан авах ажиллагааны цахим дэлгүүрээс гэрээний дагуу компьютер, тоног төхөөрөмж худалдан авч хөрөнгийг санхүүгийн тайланд толилуулж, тодруулсан байна.

D:/bichighereg/2023A4toot

006020230

### **Аудитын гол асуудал**

Тус сургуулийн 2022 оны санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудал байхгүй.

### **Бусад асуудлын хэсэг**

Байгууллагын даргын 2022 онд хэрэгжүүлэх гүйцэтгэлийн төлөвлөгөөний үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлтэд тусгагдсан 7 зорилтын хүрээнд 38 арга хэмжээ баталснаас гүйцэтгэлээр 95.5 хувийн биелэлттэй байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.ЭРДЭНЭ

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Код	Үзүүлэлт	Үлдэгдэл	Үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>100,624,068.04</u></b>	<b><u>121,623,516.87</u></b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	-	25,847,320.33
<b>312</b>	<b>Банкинд байгаа бэлэн мөнгө</b>	-	25,847,320.33
<b>3121</b>	<b>Төгрөг</b>	-	25,847,320.33
31216	Нэмэлт санхүүжилтийн арилжааны банк	-	25,847,320.33
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	39,274.00	-
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	39,274.00	-
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	100,584,794.04	95,776,196.54
35300	Бэлэн бүтээгдэхүүн	5,557,600.00	3,952,920.00
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	95,027,194.04	91,823,276.54
35460	Хүнсний материал	15,126,221.00	10,666,100.00
35470	Бусад хангамжийн материал	79,900,973.04	81,157,176.54
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>1,389,931,870.34</u></b>	<b><u>1,363,314,204.80</u></b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	1,389,931,870.34	1,363,314,204.80
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	1,320,075,370.34	1,293,795,204.80
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,349,484,248.70	1,318,633,548.70
39202	Хуримтлагдсан элэгдэл	(131,443,223.00)	(168,848,048.12)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	265,949,831.00	118,843,404.30
39206	Хуримтлагдсан элэгдэл	(218,906,993.36)	(41,067,380.72)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	68,449,019.93	81,315,729.43
39208	Хуримтлагдсан элэгдэл	(28,154,605.37)	(28,948,629.81)
39214	Бусад үндсэн хөрөнгө	43,332,010.00	21,678,337.50
39215	Хуримтлагдсан элэгдэл	(31,547,895.56)	(10,707,294.72)
39217	Ном	2,912,978.00	2,895,538.24
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	69,856,500.00	69,519,000.00
39301	Програм хангамж	2,587,798.00	2,587,798.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(1,575,298.00)	(1,912,798.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	68,844,000.00	68,844,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b><u>1,490,555,938.38</u></b>	<b><u>1,484,937,721.67</u></b>
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b><u>1,490,555,938.38</u></b>	<b><u>1,484,937,721.67</u></b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	1,490,555,938.38	1,484,937,721.67
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	666,081,812.58	666,081,812.58
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	(480,970,277.80)	(478,939,793.91)
51210	Өмнөх үеийн үр дүн	(480,970,277.80)	(473,321,577.80)
51220	Тайлант үеийн үр дүн	-	(5,618,216.11)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,305,444,403.60	1,297,795,703.00
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b><u>1,490,555,938.38</u></b>	<b><u>1,484,937,721.67</u></b>

“ЦЭСБ аудит” ХХК

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Код	Үзүүлэлт	Гүйцэтгэл	Гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>1,457,378,629.85</b>	<b>1,552,708,145.30</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>361,409,365.85</b>	<b>53,424,773.30</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	1,500,000.00	-
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	1,500,000.00	-
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,500,000.00	-
<b>121</b>	<b>Хөрөнгийн орлого</b>	22,223,165.85	53,424,773.30
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Үндсэн хөрөнгө	7,343,395.00	50,316,989.30
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Бараа материал	14,879,770.85	3,107,784.00
<b>123</b>	<b>Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг</b>	337,686,200.00	-
123001	Тусгай зориулалтын шилжүүлгийн орлого	337,686,200.00	-
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>1,095,969,264.00</b>	<b>1,499,283,372.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	1,002,975,200.00	1,094,529,900.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	12,908,300.00	1,094,529,900.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	990,066,900.00	-
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	579,049.00	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	579,049.00	-
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	92,415,015.00	404,753,472.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	92,415,015.00	404,753,472.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>1,146,269,530.80</b>	<b>1,517,910,406.51</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,146,269,530.80</b>	<b>1,517,910,406.51</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	1,113,414,663.80	1,465,815,406.51
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	784,288,408.00	848,223,129.59
210101	Үндсэн цалин	523,079,546.00	610,346,538.59
210102	Нэмэгдэл	211,700,773.00	187,889,762.00
210104	Урамшуулал	49,508,089.00	49,986,829.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>103,572,201.00</b>	<b>106,492,256.08</b>
210201	Тэтгэврийн даатгал	72,289,127.00	72,957,164.82
210202	Тэтгэмжийн даатгал	7,725,581.00	8,449,866.44
210203	ҮОМШӨ-ний даатгал	6,238,200.00	6,752,704.74
210204	Ажилгүйдлийн даатгал	1,526,324.00	1,658,298.98
210205	Эрүүл мэндийн даатгал	15,792,969.00	16,674,221.10
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>91,415,015.00</b>	<b>323,541,860.00</b>
210301	Гэрэл, цахилгаан	17,987,315.00	17,128,141.00
210302	Түлш, халаалт	72,000,000.00	305,853,719.00
210303	Цэвэр, бохир ус	1,427,700.00	560,000.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>17,253,426.60</b>	<b>4,866,080.50</b>
210401	Бичиг хэрэг	540,049.00	102,000.00
210402	Тээвэр, шатахуун	2,895,550.00	-
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	461,000.00	-
210404	Ном, хэвлэл	150,900.00	-
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,310,900.00	750,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	10,895,027.60	-
210408	Бараа материал акталсны зардал	-	4,014,080.50
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>34,715,150.00</b>	<b>62,835,675.00</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	461,900.00	-
210502	Хоол, хүнс	32,824,850.00	62,835,675.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,428,400.00	-

<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>2,500,000.00</b>	<b>14,200,000.00</b>
210604	Урсгал засвар	2,500,000.00	14,200,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>321,000.00</b>	<b>-</b>
210702	Дотоод албан томилолт	321,000.00	-
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>5,934,700.00</b>	<b>8,830,400.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	5,934,700.00	1,775,800.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	-	7,054,600.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>73,414,763.20</b>	<b>96,826,005.34</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	21,805,906.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,355,640.00	10,423,600.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	70,059,123.20	64,596,499.34
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>32,854,867.00</b>	<b>52,095,000.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>19,528,000.00</b>	<b>52,095,000.00</b>
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	18,828,000.00	52,095,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	700,000.00	-
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>13,326,867.00</b>	<b>-</b>
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	13,326,867.00	-
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>311,109,099.05</b>	<b>34,797,738.79</b>
<b>225</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>-</b>	<b>40,415,954.90</b>
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	-	40,415,954.90
<b>4</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)</b>	<b>-</b>	<b>(40,415,954.90)</b>
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>311,109,099.05</b>	<b>(5,618,216.11)</b>

“ЦЭСБ аудит” ХХК

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Код	Үзүүлэлт	Гүйцэтгэл	Гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>1,435,155,464.00</b>	<b>1,499,283,372.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>339,186,200.00</b>	-
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	1,500,000.00	-
120004	<b>Төсөв байгууллагын өөрийн орлого</b>	1,500,000.00	-
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,500,000.00	-
<b>123</b>	<b>Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг</b>	337,686,200.00	-
123001	Тусгай зориулалтын шилжүүлгийн орлого	337,686,200.00	-
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>1,095,969,264.00</b>	<b>1,499,283,372.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	1,002,975,200.00	1,094,529,900.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	12,908,300.00	1,094,529,900.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	990,066,900.00	-
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	579,049.00	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	579,049.00	-
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	92,415,015.00	404,753,472.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	92,415,015.00	404,753,472.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>1,078,454,964.00</b>	<b>1,445,358,251.67</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,078,454,964.00</b>	<b>1,445,358,251.67</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>1,043,105,337.00</b>	<b>1,394,488,431.67</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>784,288,408.00</b>	<b>848,323,129.59</b>
210101	Үндсэн цалин	523,079,546.00	610,446,538.59
210102	Нэмэгдэл	211,700,773.00	187,889,762.00
210104	Урамшуулал	49,508,089.00	49,986,829.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>103,611,475.00</b>	<b>106,352,982.08</b>
210201	Тэтгэврийн даатгал	72,328,401.00	72,817,893.13
210202	Тэтгэмжийн даатгал	7,725,581.00	8,440,731.09
210203	ҮОМШӨ-ний даатгал	6,238,200.00	6,752,704.59
210204	Ажилгүйдлийн даатгал	1,526,324.00	1,667,431.39
210205	Эрүүл мэндийн даатгал	15,792,969.00	16,674,221.88
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>91,415,015.00</b>	<b>323,541,860.00</b>
210301	Гэрэл, цахилгаан	17,987,315.00	20,996,060.00
210302	Түлш, халаалт	72,000,000.00	301,545,800.00
210303	Цэвэр, бохир ус	1,427,700.00	1,000,000.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>5,863,639.00</b>	<b>750,000.00</b>
210401	Бичиг хэрэг	540,049.00	-
210402	Тээвэр, шатахуун	2,382,590.00	-
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	461,000.00	-
210404	Ном, хэвлэл	150,900.00	-
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,323,700.00	750,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,005,400.00	-
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>42,441,500.00</b>	<b>57,996,054.00</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	461,900.00	-
210502	Хоол, хүнс	40,551,200.00	57,996,054.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,428,400.00	-

<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>2,500,000.00</b>	<b>14,200,000.00</b>
210604	Урсгал засвар	2,500,000.00	14,200,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>321,000.00</b>	<b>-</b>
210702	Дотоод албан томилолт	321,000.00	-
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>5,934,700.00</b>	<b>9,170,400.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	5,934,700.00	1,775,800.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	-	7,394,600.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>6,729,600.00</b>	<b>34,154,006.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	23,062,106.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	6,729,600.00	11,091,900.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>35,349,627.00</b>	<b>50,869,820.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>22,022,760.00</b>	<b>50,869,820.00</b>
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	21,322,760.00	50,869,820.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	700,000.00	-
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>13,326,867.00</b>	<b>-</b>
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	13,326,867.00	-
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b>356,700,500.00</b>	<b>53,925,120.33</b>
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b>6,106,000.00</b>	<b>28,077,800.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>6,106,000.00</b>	<b>28,077,800.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>6,106,000.00</b>	<b>28,077,800.00</b>
222001	Тоног төхөөрөмж	6,000,000.00	28,077,800.00
223001	Бусад хөрөнгө	106,000.00	-
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b>(6,106,000.00)</b>	<b>(28,077,800.00)</b>
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	<b>350,594,500.00</b>	<b>25,847,320.33</b>
<b>10</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>-</b>	<b>25,847,320.33</b>

“ЦЭСБ аудум” ХХК

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	666,081,812.58	1,305,444,403.00	(480,970,277.80)	1,490,555,938.38
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	666,081,812.58	1,305,444,403.00	(480,970,277.80)	1,490,555,938.38
C08	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	666,081,812.58	1,305,444,403.00	(480,970,277.80)	1,490,555,938.38
D01	2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	666,081,812.58	1,305,444,403.00	(480,970,277.80)	1,490,555,938.38
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	7,648,700.00	7,648,700.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	666,081,812.58	1,305,444,403.00	(473,321,577.80)	1,498,204,638.38
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	(7,648,700.00)	-	(7,648,700.00)
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	(5,618,216.11)	(5,618,216.11)
D09	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	666,081,812.58	1,297,795,703.00	(478,939,793.91)	1,484,937,722.27

“ЦЭСБ аудит” ХХК

## 2.5 Төсвийн гүйцэтгэлийн тайлан

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан	Зөрүү	
				Дүн	Хувь
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>1,094,529,900.00</b>	<b>1,068,682,579.67</b>	<b>25,847,320.33</b>	<b>97.6</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,094,529,900.00</b>	<b>1,068,682,579.67</b>	<b>25,847,320.33</b>	<b>97.6</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>1,043,660,000.00</b>	<b>1,017,812,759.67</b>	<b>25,847,240.33</b>	<b>97.5</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>810,981,300.00</b>	<b>789,223,335.59</b>	<b>21,757,964.41</b>	<b>97.3</b>
210101	Үндсэн цалин	618,292,200.00	560,750,163.59	<b>57,542,036.41</b>	<b>90.7</b>
210102	Нэмэгдэл	165,102,000.00	182,490,908.00	<b>(17,388,908.00)</b>	<b>110.5</b>
210104	Урамшуулал	27,587,100.00	45,982,264.00	<b>(18,395,164.00)</b>	<b>166.7</b>
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>101,372,500.00</b>	<b>99,191,164.08</b>	<b>2,181,335.92</b>	<b>97.8</b>
210201	Тэтгэврийн даатгал	68,933,400.00	67,904,907.23	<b>1,028,492.77</b>	<b>98.5</b>
210202	Тэтгэмжийн даатгал	8,109,800.00	7,862,733.21	<b>247,066.79</b>	<b>97.0</b>
210203	ҮОМШӨ-ний даатгал	6,487,800.00	6,290,306.52	<b>197,493.48</b>	<b>97.0</b>
210204	Ажилгүйдлийн даатгал	1,622,000.00	1,557,572.62	<b>64,427.38</b>	<b>96.0</b>
210205	Эрүүл мэндийн даатгал	16,219,500.00	15,575,644.50	<b>643,855.50</b>	<b>96.0</b>
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>57,996,900.00</b>	<b>57,996,054.00</b>	<b>846.00</b>	<b>100.0</b>
210502	Хоол, хүнс	57,996,900.00	57,996,054.00	<b>846.00</b>	<b>100.0</b>
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>9,170,400.00</b>	<b>9,170,400.00</b>	-	<b>100.0</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,775,800.00	1,775,800.00	-	<b>100.0</b>
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	7,394,600.00	7,394,600.00	-	<b>100.0</b>
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>64,138,900.00</b>	<b>62,231,806.00</b>	<b>1,907,094.00</b>	<b>97.0</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	53,047,000.00	51,139,906.00	<b>1,907,094.00</b>	<b>96.4</b>
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	11,091,900.00	11,091,900.00	-	<b>100.0</b>
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>50,869,900.00</b>	<b>50,869,820.00</b>	<b>80.00</b>	<b>100.0</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>50,869,900.00</b>	<b>50,869,820.00</b>	<b>80.00</b>	<b>100.0</b>
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	50,869,900.00	50,869,820.00	<b>80.00</b>	<b>100.0</b>
<b>III</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>1,094,529,900.00</b>	<b>1,094,529,900.00</b>	-	<b>100.0</b>
<b>31</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>1,092,754,100.00</b>	<b>1,094,529,900.00</b>	<b>(1,775,800.00)</b>	<b>100.2</b>
310001	Улсын төсвөөс санхүүжих	1,092,754,100.00	1,094,529,900.00	<b>(1,775,800.00)</b>	<b>100.2</b>
<b>35</b>	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	<b>1,775,800.00</b>	<b>0.00</b>	<b>1,775,800.00</b>	-
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,775,800.00	0.00	<b>1,775,800.00</b>	-
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	25,847,320.33	<b>(25,847,320.33)</b>	

## **САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА**

---

### **3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа**

#### ***Байгууллагын үйл ажиллагааны чиглэл, зорилго, зорилтын талаар***

Сэлэнгэ сумын Ерөнхий боловсролын сургууль нь сургалтын үйл ажиллагаа явуулдаг, Боловсрол, шинжлэх ухааны яамны харьяа байгууллага юм. Тайлант онд "Эрдэм мэдлэгтэй, амьдрах ухаантай, бүтээлч, хүнлэг, энэрэнгүй, эрүүл чийрэг иргэн болгон төлөвшүүлэн ажиллах" гэсэн зорилт дэвшүүлэн ажиллажээ.

Үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Салбарын бодлого, хууль тогтоомж, шийдвэрийн хэрэгжилтийг зохион байгуулах, ерөнхий боловсролын сургуулийн хөгжлийг төлөвлөх, хэрэгжүүлэх, хяналт-шинжилгээ, үнэлгээ,
- Бага дунд боловсролын сургалтын хөтөлбөр, төлөвлөгөө, сургалтын арга зүй, технологийг хөгжүүлэх,
- Байгууллагын хүний нөөцийн хөгжил, төлөвшлийг хангах, багшийн хөгжлийг дэмжих,
- Байгууллагын санхүүгийн болон материаллаг нөөцийг төлөвлөх, хэрэгжүүлэх, суралцагч, багш ажилтныг эрүүл, аюулгүй таатай орчинд сурч төлөвших, ажиллах нөхцөлийг бүрдүүлэх чиг үүрэг бүхий байгууллага юм.

### **3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин**

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Монгол Улсын 2022 оны Төсвийн тухай хуулиар төсөв, санхүүжилтийг баталсан,
- Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгыг 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс дагаж мөрдсөн байна.
- Төрийн хэмнэлтийн тухай тухай хууль хэрэгжиж эхэлсэн,
- Төрийн албаны тухай хуульд 2022 оны 04 дүгээр сарын 22, 07 дугаар сарын 05, 11 дугаар сарын 11-нд нэмэлт өөрчлөлт орсон.
- Боловсролын тухай хуульд 2022 онд 3 удаа нэмэлт өөрчлөлт орсон,
- ЗГ-ын 2022 оны 91 дүгээр тогтоолоор батлагдсан "Хувьсах зардлын дундаж норматив, аргачлал батлах тухай" журам хэрэгжиж эхэлсэн,
- ЗГ-ын 2019 оны 472 дугаар тогтоолын 5, 6 дугаар хавсралтаар батлагдсан "Шинжлэх ухааны байгууллага, сургуулийн өмнөх болон бага, дунд боловсрол эзэмшүүлэх сургалтын байгууллагын төрийн үйлчилгээний албан тушаалын цалингийн сүлжээ батлах тухай" тогтоолд 2022 оны 107 дугаар тогтоолоор батлагдсан "Үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн цалингийн доод хэмжээг тогтоох тухай" тогтоол, 2022 оны 192 дугаар тогтоолоор нэмэлт өөрчлөлт оруулсан,
- ЗГ-ын 2019 оны 5 дугаар тогтоолын гуравдугаар хавсралтаар батлагдсан "Төрийн болон орон нутгийн өмчийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын багш, туслах багш, албан хаагчид олгох улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшуулал олгох" тогтоолд 2022 оны 252 дугаар тогтоолоор нэмэлт өөрчлөлт оруулсан,
- БШУС-ын 2022 оны А/170 дугаар тушаалаар батлагдсан "Хичээл, сургалтын үйл ажиллагааны зардлыг төлөвлөх, хуваарилах заавар"-ыг хэрэгжүүлж эхэлсэн,

- БШУС-ын 2022 оны А/465 дугаар тушаалаар батлагдсан “Ерөнхий боловсролын сургуульд, кабинет, лаборатори, цахим сургалтын танхим байгуулах, ашиглах нийтлэг журам”-ыг шинэчлэн баталсан

Төсвийн шууд захирагч батлагдсан төсөвт үндэслэн зарлагын гүйлгээнд гарын үсэг зурснаар дотоод хяналтыг хэрэгжүүлж байгаа бол аймгийн төрийн сан холбогдох санхүүгийн баримт материал, гэрээ, гүйцэтгэлийн баримт бичгийг хянаж, зарлагын гүйлгээг хийж байна. Иймд төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг үр нөлөөтэй гэж тодорхойлсон тул гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэх шаардлагагүй гэж үзсэн.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Тус сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Аймгийн Засаг даргын 2020 оны 9 дүгээр сарын 29-ний өдрийн А/424 захирамжаар баталсан Булган аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн багцын төсөвт байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг мөрдөж байна. Энэ нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Сэлэнгэ сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна. Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тус сургуулийн 2022 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 5,618.2 мянган төгрөгөөр буюу 0.38 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс үндсэн хөрөнгийн дансанд материаллаг өөрчлөлт гарсан байна.

Хүснэгт 1: Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	25,847.3	25,847.3
Авлага	39.3	-	-
Байгууллагаас авах авлага	-	-	-
Бараа материал	100,584.7	95,776.2	(4,808.6)
Үндсэн хөрөнгө	1,389,931.8	1,363,314.2	(26,617.6)
Үндсэн хөрөнгийн элэгдэл		(64,596.5)	
<b>Нийт хөрөнгө</b>	<b><u>1,490,555.9</u></b>	<b><u>1,484,937.7</u></b>	<b><u>(5,618.2)</u></b>
Өр төлбөр		-	-
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	1,490,555.9	1,484,937.7	(5,618.2)
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b><u>1,490,555.9</u></b>	<b><u>1,484,937.7</u></b>	<b><u>(5,618.2)</u></b>

Тайлант жилийн үйл ажиллагааны зардлын хэмнэлт 25,847.3 мянган төгрөгийг Засгийн газрын 2022 оны 91 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралт “Хувьсах зардлын дундаж нормативаар төсөв хуваарилах, санхүүжүүлэх аргачлал”-ын 8.7-д “Боловсролын сургалтын байгууллагын жилийн эцсийн дансны үлдэгдлийг дараагийн төсвийн жилд шилжүүлнэ.” гэж заасны дагуу төрийн сангийн харилцах дансанд үлдэгдлээр тайлагнагдсан байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 95,776.2 мянган төгрөг болж 4,808.6 мянган төгрөгөөр буурсан нь тайлант оны хүнсний материалын зарцуулалттай холбоотой байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 1,363,314.2 мянган төгрөг болж 26,617.6 мянган төгрөгөөр буурчээ. БШУС-ын 2022 оны 11 дүгээр сарын 08-ны өдрийн А/452 дугаар тушаалаар техник, тоног төхөөрөмжийн нөхөн хангалтын зардалд хуваарилсан 28,077.8 мянган төгрөгөөр төрийн худалдан авах ажиллагааны цахим дэлгүүрээс компьютер, тоног төхөөрөмж худалдан авсан, хандиваар 3,142.1 мянган төгрөгийн 10 ширхэг морин хуур, 2 ширхэг багш ширээ, үнэ төлбөргүй 21,866.2 мянган төгрөгийн тавилга эд хогшил, тоног төхөөрөмжийг хүлээн авсан байна. Аймгийн Орон нутгийн өмчийн газрын 2022 оны 11 дүгээр сарын 16-ны өдрийн 218 тоот албан бичгийн үндэслэн элэгдлээрээ өртгөө нөхсөн цаашид ашиглах боломжтой 23,541.8 мянган төгрөгийн хөрөнгийг бүртгэл тусгасан байна.

Мөн аймгийн ИТХ-ын ээлжит 10 дугаар хуралдааны тогтоолоор 7,648.7 мянган төгрөгийн Атар багийн сургуулийн барилга, 122,900.0 мянган төгрөгийн уурын зуухны тоног төхөөрөмж, 1,593.5 мянган төгрөгийн хашаа, усан оргилуур, Сэлэнгэ сумын ИТХ-ын 09/06 дугаар тогтоолоор 11,213.3 мянган төгрөгийн ашиглалтын хугацаа дууссан тавилга эд хогшил, нийт 152, 355.4 мянган төгрөгийн хөрөнгө акталсан нь үндсэн хөрөнгө 26,617.6 мянган төгрөгөөр буурахад нөлөөлжээ.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1,484,937.7 мянган төгрөг болж 5,618.2 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнтэй холбоотой.

### **3.5. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### **3.5.1 Төсвийн төлөвлөлт**

Сэлэнгэ сумын Ерөнхий боловсролын сургууль 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр болон нийт зарлагыг 1,744,862.2 мянган төгрөгөөр тооцон төсөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлснийг 1,094,529.9 мянган төгрөгөөр баталж, 650,332.3 төгрөгөөр бууруулсан байна. Үүнд цалин хөлс, нэмэгдлийг 415,769.4 мянга, нормативт зардлыг 50,900.5 мянга, төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшууллын зардлыг /үдийн цай/ 50,869.8 мянган төгрөгөөр хасаж баталсан нь төсвийн төлөвлөлттэй холбоотой байна. Харин бараа үйлчилгээний бусад зардалд бичиг хэрэг, тээвэр шатахуун, дотоод албан томиллол зэрэг зардлуудыг нэмэгдүүлж 60,737.4 мянган төгрөгөөр баталжээ.

Дээд шатны төсөв захирагчаас төсвийг зардлын эдийн засгийн ангиллаар нь бус “бараа үйлчилгээний бусад зардал” гэсэн ангиллаар бөөнд нь тусган, төлөвлөж, баталж байгаа нь төсвийг зардлын бүлэг, зүйлээр төлөвлөж, зарцуулах, зарцуулалтад хяналт тавих зарчмыг алдагдуулж байна. Иймд төсвийг бодит гүйцэтгэлтэй нь уялдуулан зардлын бүлэг, зүйл бүрээр төлөвлөж, зарцуулан гүйцэтгэж байх шаардлагатай байна.

### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 11 арга хэмжээг санхүүжүүлэхээр улсын төсвөөс 1,094,529.9 мянган төгрөгийг баталж, орон нутгийн төсвөөс 404,753.5 мянган төгрөгийн санхүүжилт хуваарилжээ.

Гүйцэтгэлээр санхүүжилтийг 100 хувь олгож, 25,847.3 мянган төгрөг зарцуулаагүй үлдэгдлээр тайлагнасан байна. Нийт зардлын 64.8 хувийг цалин хөлс болон нэмэгдэл урамшил, ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэлийн зардал, 21.9 хувийг байр ашиглалттай холбоотой тогтмол зардал эзэлж байгаа бол дотуур байрны хоол, хүнс, үдийн хоолны зардал 3.5-3.9 хувийг эзэлж байна.

*Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл*

Хөтөлбөр	д/д	Арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	зөрүү	Биелэлт
<b>71802 Ерөнхий боловсрол</b>	1	81801- Үдийн цай хөтөлбөр	50,869.9	50,869.9	-	-
	2	80111- Төрийн өмчийн барилгын тогтмол зардал				
	3	80112- Нийтлэг үйлчилгээ	134,023.4	134,023.3	0.1	
	4	80226- Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	323,545.8	323,541.9	3.9	
	5	80312- Сургалт семинар	1,478.9	1,478.9		
	6	81605- Эрүүл мэндийг дэмжих	3,401.5	3,401.5		
	7	81806- Дотуур байрны хүүхдийн хоол	75,867.0	75,274.1	592.9	
	9	81816- Хүүхдэд ээлтэй сургалтын орчин				
	10	81823- Боловсролын багшийн сургалт	6,655.1	6,641.4	13.7	
	11	81834- Боловсролын стандарт сургалт	803,218.7	785,014.5	18,204.2	
	12	81835- Сургалтын хэвийн үйл ажиллагаа	118,335.2	113,190.9	5,144.3	
			Зөв монгол хүүхэд үндэсний хөтөлбөр	29,970.0	28,077.8	1,892.2
<b>Нийт</b>			<b>1,094,529.9</b>	<b>1,068,682.6</b>	<b>25,847.3</b>	<b>95.5</b>

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.5.3 Нэмэлт төсөв:

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансаар төвлөрсөн орлого байхгүй.

## **4. АУДИТЫН ТАЙЛАН**

---

### **4.1 Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Сэлэнгэ сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлж ажиллах тухай өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг “ЦЭСБ аудит” ХХК-ийн аудитор Ш.Ганчимэг, аудиторын туслах Б.Гантуяа нар гүйцэтгэж, хяналтыг Булган аймаг дахь Төрийн аудитын газрын аудитын менежер Ж.Энхцоодол, дарга, тэргүүлэх аудитор Б.Эрдэнэ нар тус тус хэрэгжүүлсэн.

Сэлэнгэ сумын ЕБС 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Булган аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 1 дүгээр сарын 25-ны өдрийн 01 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

### **4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр батлагдсан төсвийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны батлагдсан төсвийн 1,094,529.9 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 10,945.3 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### **4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор төрийн хэмнэлтийн тухай хууль болон Засгийн газрын 2022 оны 203 дугаар тогтоолыг хэрэгжүүлж ажилласан байна. Боловсролын салбарын үр дүнд суурилсан санхүүжилтийг нэвтрүүлж батлагдсан орон тоогоор бус гүйцэтгэлээр санхүүжүүлсэнтэй холбоотойгоор цалин, хөлс болон нэмэгдэл урамшуулал, ажил олгогчоос төлөх НДШ, бараа үйлчилгээний бусад зардлаас 25,847.3 мянган төгрөгийн хэмнэлтийг бий болгожээ.

### **4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

#### **4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг

стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд боловсролын байгууллагын мэдээлбэл зохих 20 төрлийн 151 мэдээллээс 4 мэдээллийг хугацаа хоцроож, бусад мэдээллийг хугацаанд нь бүрэн мэдээлсэн байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

#### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

##### 4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудит хийгээгүй болно.

##### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	3	800.9	3	800.9	100
Албан шаардлага	2	0	1	0	100
Зөвлөмж	2	39.3	2	39.3	100
<b>Нийт дүн</b>	<b>7</b>	<b>840.2</b>	<b>3</b>	<b>840.2</b>	<b>100</b>

Өмнөх аудитаар өгсөн 39.3 мянган төгрөгийн 2 зөвлөмж, 1 албан шаардлага, 800.9 мянган төгрөгийн 3 төлбөрийн акт, зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлсэн байна.

#### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй болно.

### 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 1,100,073.4 мянган төгрөгийн алдаа<sup>1</sup> зөрчил илэрснээс аудитын явцад 3,147.1 мянган төгрөгийн алдааг залруулж, 1,096,926.3 мянган төгрөгийн 1 зөвлөмж өглөө.

#### 5.1 Зөвлөмж

1. Шилэн дансны хуулийн хэрэгжилттэй холбоотой асуудал

##### Илрүүлэлт:

Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө 1,556.2 мянган төгрөг, батлагдсан төсөв 1,094,529.9, мянган төгрөг, аудитын дүгнэлт, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээ 840.2 мянган төгрөгийн, хөрөнгийн зардал, урсгал зардалд тусгагдсан арга хэмжээ, тендерийн ерөнхий мэдээллийг хугацаа хоцроосон нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар

<sup>1</sup> Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

